

## МОНГОЛ УЛС ДАХЬ СОЛОНГОСЫН СУДЛАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

*Т.Намжил\**

Түүхийн үүднээс үзвэл Монгол, Солонгосчууд харилцааны эртний уламжлалтай. Орчин үеийн Монгол улс, БНСУ-ын хооронд улс төрийн харилцаа тогтоод арван гурван жил болж байна. Энэ нь түүхийн хувьд богино хугацаа. Гэхдээ хоёр орны харилцааны үндэс тавигдсан, хамтын ажиллагааны агуулга, хэлбэр тогтсон, өргөжих хандлага бий болсон үе. Тиймээс ч Монгол, Солонгосын харилцааг судлах бололцоог бидэнд олгож байгаа юм.

Монгол улс, БНСУ-ын харилцаа, хамтын ажиллагаа, хоёр талын идэвхитэй чармайлт, харилцан ойлголцлол итгэлцэлийн үрээр:

Улс төрийн хүрээнд: хоёр орны удирдагчдын дээд хэмжээний айлчлал, уулзалт, гэрээ, хэлэлцээ явагдаж, хоёр орны харилцааны эрх зүйн үндэс тавигджээ. Ингэснээр хоёр орны харилцааг хөгжүүлэх арга зам, ажиллагааг олон улсын харилцааны нийтлэг чиг хандлагатай уялдуулах, бүс нутгийн интеграцид оролцох агуулга, хэлбэрийг тодорхойлоход чухал ач холбогдолтой болсон юм.

Эдийн засгийн хүрээнд: харилцаа олон хэлбэрээр үүсч, хөгжих эхлэл бий боллоо. Үүний тод жишээ нь худалдааны эргэлт, хэмжээ өсч байгаа явдал юм. Дагнасан ба хамтарсан компаниудын тоо өсч үйл ажиллагааных нь хүрээ нэмэгдэж байна.

Бүс нутгийн болон олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагад оролцох Монгол улсын оролцоог нэмэгдүүлэхэд БНСУ зохих дэмжлэг тусалцаа үзүүлж байна.

Соёлын харилцааны хүрээнд: урлаг, боловсрол, шинжлэх ухаан, спорт, мэдээлэл, жуулчлал, олон нийтийн байгууллагуудын хооронд урлаг, соёлын зүтгэлтэн, багш, оюутан, эрдэмтэн судлаачдын төлөөлөгчдийг харилцан солилцох, хурал ярилцлага зохион байгуулах, Солонгос хэл, соёлын төв ажиллуулах зэрэг хэлбэрээр хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байна. Өнгөрсөн зуунд Солонгост Монгол судлал, Монголд Солонгос судлал хэл, түүхийн чиглэл голлон тус тусдаа хөгжих болжээ.

Монгол улсад 1970-аад оноос Солонгосын судлалаар ажиллах судлаачид бий болж эхэлжээ. Солонгос хэл дээрх ном зохиолоос Монголын холбогдолтой хэрэглэгдхүүнийг монгол хэл дээр орчуулан

---

\*Т.Намжил - Улаанбаатар дээд сургуулийн Монгол судлалын төвийн захирал, доктор (Sc.D), профессор

монгол судлалын эрдэмтэн нарт гарын авлага болгон нийтлүүлж буй анхны эрдэмтэн бол Шинжлэх ухааны доктор Б.Сумъябаатар юм. Тэрээр “Монгол Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд” /1975/ бүтээлдээ эртний Солонгос аймаг, түүний төв Азитай холбогдох нь, Монгол, Солонгос хэлний учир холбогдол, Монгол, Солонгос хэлний харьцуулсан авиа зүй, үсэг зүйн чухал асуудлуудыг судалжээ. Түүнчлэн “Дундад зууны Солонгос, Монгол харилцааны түүх”, “XIII-XIV зууны Монгол, Солонгосын харилцааны бичгүүд”, /1992/ гаргасан нь судлаачдын гарын авлага хэрэглэгдхүүн болж байна. Академич Ч.Далай доктор Сумъябаатарыг “Монгол улсын чадалтай доктор, Солонгос судлалын мэргэжилтэн” гэж үнэлсэн байдаг.

Доктор Ц.Шагдарсүрэн “Монгол, Солонгосын бичиг үсгийн харилцаа холбооны асуудалд” /1996/ өгүүлэлдээ Солонгос, Монгол үсэг бичгийн дотоод тогтолцоо/тухайн үсэг бичгийг боловсруулахад баримталсан онолын үндэслэл/-г харьцуулан судлах зорилгыг тавьжээ. Тэрээр Солонгос бичиг үсгийн гадагшаа нөлөөлсөн нөлөө тусгалын зам, учир холбогдлыг тодруулах нь бичиг үсгийн холбооны асуудал төдийгүй Төв Ази дахины олон улс үндэстний нийгэм-улс төр, соёл боловсролын өргөн харилцааны түүхэнд үлэмжхэн ач холбогдолтой болно гэж үзэж байна гэжээ.

Хэл шинжлэлийн дээрх эрдэмтэдээс гадна түүхийн шинжлэх ухааны дэд доктор Б.Лхагваа, Академич Ч.Далай нар Солонгосын сурвалжыг судлах ажлыг хийж байна.

Эрдэмтэн Б.Лхагваа “XIII-XIV зууны үеийн Монгол Солонгосын харилцаа” эрдэм шинжилгээний бүтээлдээ монгол солонгос туургатны хамаарал, XIII-XIV зууны монгол, солонгосын харилцаа тухайлбал: Нийгэм улс төрийн хүрээн дэх төрийн ургийн барилдлага, түүний улс төр, соёлын нөлөөлөл, шинжлэх ухаан, соёл боловсролын холбоо, нөлөөлөл уламжлалаас судалжээ.

Академич Ч.Далай Монгол, Солонгосын түүхэн харилцааны зарим асуудлыг хөндөхдөө Солонгос сурвалжыг голлон түшиглэсэнээс гадна Монголын талын сурвалж хэрэглэгдхүүн, домог яриаг аль болохоор ашиглахыг хичээжээ. Ч.Далай “Монгол, Солонгосын эртний түүхэн харилцаа”/1998/ бүтээлдээ 1990 онд Соул хотноо хэвлэсэн гурван боть “Гуулин улсын судар”-ыг гол хэрэглэгдхүүнээ болгосон байна. “Зүүн гүрний цэргийн толь”, “Гуулин улсын түүх”, “Гуулин улсын судар” зэрэг Солонгос сурвалж бичгээс монголын судлаачид ашиглах болжээ.

Т.Намжил “Монголчуудын гэр бүлийн хүмүүжлийн уламжлал, түүнийг зүүн хойт Азийн орнуудтай харьцуулан судалсан нь” сэдвээр Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж/1997/ “Монголын гэр бүл” цувралын хүрээнд “Монгол ба зүүн хойт Азийн гэр бүл”, “Монгол өрнө дорно: Гэр бүлийн заншлын уламжлал холбоо” зэрэг номнууд бичиж Монгол дахь Солонгосын судлалд гэр бүлийн гэсэн чиглэлийг гаргасан байна.

Археологич, түүхийн шинжлэх ухааны доктор Д.Баяр Монгол, Солонгосын нутагт буй хүн чулууны харьцуулсан судалгаа хийж, эрдэм шинжилгээний өгүүлүүд нийтлүүлжээ.

Ж.Баттөр, Б.Норовням нарын залуу эрдэмтэд судаачид Солонгос судлаач ахмад эрдэмтэдийнхээ залгамж үе болон гарч ирж байна.

Солонгос судлалд эдийн засгийн судалгаа идэвхтэй хөгжиж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Сүүлийн үед Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэн энэ чиглэлийн судалгааг идэвхитэй хийж эхэллээ.

Монгол улс, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойших хугацаанд Монгол, Солонгос судлал өргөжлөө. Хоёр орны аль алинд нь өвөг дээдсээс үлдээсэн соёлын үнэт зүйлс, тухайлбал сурвалж, хөшөө дурсгал, угсаатны зүй, археологийн олон тооны хэрэглэгдхүүн материал байдгийг бид бүгдээр мэддэг: Эдгээрийг харилцан судлах, судалгааны үр дүн, мэдээллийг харилцан солилцох, ном бүтээл бичих, харилцан орчуулах, хэвлэн нийтлэх, эрдэм шинжилгээний хамтарсан экспедиц ажиллуулах, хурал хийх зэрэг ажлууд зохиогджээ.

Солонгос дахь Монгол судлалын нийгэмлэгийн тэргүүн Чой Ги Хо-гийн тэмдэглэснээр: 1990 оноос хойш 10 жилийн хугацаанд Солонгосын Монгол судлалын нийгэмлэг Монголд хамтын судалгааг Хэнтий аймаг, Дарьганга, Буйр нуур, Хархорин, Төв аймаг, Хөвсгөлийн цаатны нутгууд болон Ордос, Байгаль нуур зэрэг газарт угсаатны зүй, хэл шинжлэл, түүх, археологийн чиглэлээр хийж, дээрх судалгааны дүнд судалгааны 3 боть, “Монгол судлал” эрдэм шинжилгээний 8 боть сэтгүүл гаргасан байна.

БНСУ-ын зарим их, дээд сургуульд Монгол судлалын, Монгол улсад Солонгос судлал, солонгос хэлний анги, тэнхим нээж, харилцан багш нарыг урьж ажиллуулж байна. Монгол, БНСУ-ын аль алинд нь бүс нутгийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны болон цаг үеийн

янз бүрийн асуудал, сэдвээр зохиогдож ирсэн олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, симпозиум, зөвлөгөөн зэрэг арга хэмжээнүүдэд, эрдэм судлалын хүмүүс харилцан оролцож, санал бодлоо солилцож ирсэн нь хоёр орны хамтын ажиллагааны нэг бодитой үр дүн юм.

Монгол, Солонгосын аль алинд нь Монгол, Солонгос судлал нь хэл, түүхийн хүрээнд төдийгүй эдийн засаг, соёл, олон улсын харилцаа, археологи, этнограф зэрэг олон чиглэлээр эрт, дундад, эдүгээ цагийн хэлхээнд хийгдэх болж байна.

Монгол, БНАСАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойших хагас зуун жилийн хугацаанд харилцааны чиглэл, хэлбэр тогтож, тодорхой туршлагыг хуримтлуулжээ. Энэ явцад Монголд БНАСАУ-ын талаарх судалгаа үүссэн. Сүүлийн жилд манай эрдэмтэдээс БНАСАУ, Монголын харилцааны түүхийн асуудлаар эрдмийн зэрэг хамгаалж байна. Харин судалгааны хамрах хүрээ, чиглэлийн өргөжүүлэх шаардлагатай байгаа юм.

Солонгосын судлалыг өргөжүүлэн хөгжүүлэх боломж хэтийн төлөв их байна.

Солонгосчууд гарал үүсэл, угсаатны хувьд Монголчуудтай холбоотой, харилцан бие биедээ нэн элэгсэгдотно ханддаг, царай төрх, зан заншил, хэлний хувьд ойролцоо, шинж төрхүүд нь Монголчууд бидний хувьд ихээхэн сонирхолтой, судалгааны чиглэлийг бий болгож байна.

Эдүгээ Монгол, Солонгос, Орос /Буриад, Тува, Якут/, Хятад/ Өвөрмонголын харилцаа/, хамтын ажиллагаа өргөжиж байгаа нөхцөлд Монгол, Солонгосын судлалын ажлыг хөгжүүлэх нь шинжлэх ухаан, практикийн ач холбогдолтой асуудал болж байгааг тэмдэглэе.

Сүүлийн үед хоёр орны их, дээд сургуулиудын эрдэмтэн багш нар, судалгааны хамтлаг, олон нийтийн байгууллагад монгол, солонгос судлалыг сонирхоэн судалдаг, судлах гэсэн хүмүүсийн тоо өсөх хандлагатай байгаа нь Монгол, Солонгосын судлалд ахиц дэвшил гарахад чухал нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Монгол, Солонгосын судлалын ажлын хүрээнд өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүний тулд яах ёстой вэ? гэсэн асуудал гарч ирж байгаа юм. Монгол, Солонгосын судлалын асуудлуудаар ажиллаж байгаа, ажиллах сонирхолтой эрдэмтэд, судлаачдын хооронд холбоо тогтоох, харилцан мэдээлэл солилцох, хамтарсан судалгаа хийх, эрдэм шинжилгээний хуралд оролцуулах,

хамтын бүтээл туурвих зэрэг чиглэлийг баримтлан хөгжүүлэх нь зүйтэй болов уу.

Улаанбаатар дээд сургуулийн хувьд ч энэ чиглэлээр ажиллах бодлого сонирхолтой байна. Улаанбаатар дээд сургууль Монгол, Солонгосын судлалд анхаарал тавьж 1997 оноос Солонгосын, 2003 оноос Монгол судлалын төв байгуулан ажиллуулж байна. Энэ нь Монгол, Солонгосын судлалын ажлын уламжлалыг улам бататгаж, уг судалгааг өргөтгөн урагш ахиулахад чиглэгдсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ юм. Ер нь Монгол, Солонгосын судлалын төвийн үйл ажиллагааны гол чиглэл нь эх бичиг, хэл соёл, түүх соёл судлал юм. Улаанбаатар дээд сургууль Солонгос, Монголын судлалын ажлыг Солонгос хэлтэй залуу боловсон хүчнээр бэхжүүлэх, залуу судлаачдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхэд ихээхэн анхаарал тавьж байна. Монгол, Солонгосын судлаачдыг солонгос хэл эзэмшүүлэн бэлтгэх ангийг нээх гэж байна. Монгол, Солонгосын судлалаар магистрантурын сургалтын зохион байгуулна. Суралцагчид солонгос, монгол хэл, соёл судлал, ардын уламжлалт мэдлэг ухааны сурвалж судлал, нүүдэлчдийн соёл иргэншлийн зэрэг асуудлыг өөрсдийн сонголтын үндсэн дээр судлах бололцоотой юм. Монгол Улсад өрнөсөн ардчилал, шинэчлэлт нь монгол, солонгос судлалын ажлын хүрээг өргөжүүлж, Монгол, Солонгосын харилцаа, Солонгосын хөгжлийн туршлага, Солонгосын болоод Монгол орон судлалын чиглэл рүү хандуулах боллоо.

Бидний гол зорилго бол Доктор Б.Сумьябаатарын онцлон тэмдэглэсэнтэй адил “зөвхөн хэлний үзэгдлийг хооронд нь харьцуулан судлах хүрээнээс хальж, тэдгээр хэлийг өвлөн авч ирсэн ард түмнийх нь түүх, утга соёлын нийтлэг, угсаатны судлал, аман зохиол судлал, хуучны судлалын хэрэглэгдхүүнийг нийтэд нь ашиглан утга учрыг тодруулахад оршиж байна.”

#### Монгол Улсад Солонгос судлалыг эрхэлж байгаа байгуулагууд

1. Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэн
2. Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэн
3. МУИС-ийн Солонгос хэлний тэнхим
4. Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэн
5. Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн
6. Улаанбаатар дээд сургуулийн Солонгос судлалын төв, Монголын судлалын төв

Солонгос судлаач Монголын эрдэмтэд

1. Академич, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Ч.Далай
2. Түүхийн ухааны дэд доктор Б.Лхагваа /Монгол улсаас БНСУ-д суугаа элчин сайдын яамны ажилтан/
3. Хэл шинжлэлийн ухааны доктор Б.Сумъябаатар / Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан/
4. Түүхийн шинжлэх ухааны доктор Д.Баяр / Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгийн секторын эрхлэгч/
5. Шинжлэх ухааны доктор, професор, гэр бүл судлаач Т.Намжил /Улаанбаатар дээд сургуулийн Монгол судлалын төвийн захирал/
6. Түүхийн ухааны дэд доктор Ц.Баатар / Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан/
7. Түүхийн ухааны дэд доктор Ж.Баттөр /МУИС-ийн Солонгос хэл, судлалын тэнхмийн багш/
8. МУИС-ийн Солонгос хэл, судлалын тэнхмийн эрхлэгч, докторант Б.Норовням